



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөл зохион байгууллаа.

Ёслолын ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Саран, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Л.Идэрцогт, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Алтансүх нар оролцлоо.



Төрийн захиргааны албан хаагчаар томилогдсон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газрын Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Б.Ганчимэг, Мал эмнэлгийн хяналт, эрсдэлийн үнэлгээний газрын мэргэжилтэн Ч.Лувсанжанцан, Нийслэлийн Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн хяналт, эрсдэлийн үнэлгээний хэлтсийн улсын байцаагч С.Цэрэнбат, Жижиг, дунд үйлдвэрийн газрын Бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Д.Балжинням нар **“Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ”** хэмээн Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөлөө.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ